

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН 01 ДУГААР ТОГТООЛЫН
БИЕЛЭЛТИЙН ХАРИУ ТАЙЛАН**

2023.06.20

Бүрд сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Аймгийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журамтай болгох асуудлыг шийдвэрлэх	2023 онд малын тэжээл болох долооц-50 хайрцааг, хивэг /40 кг-/448 уут, хивэг /25 кг-/883 уут, малын өвс-612 боодол суманд ирж малчдад хөнгөлөлттэй үнээр борлуулж ажилласан.
2	2023.01.01-нээс Шилэн дансны шинэ нэгдсэн цахим системд нэвтрэх болсонтой холбогдуулж 2022.12-р сард багтаан байгууллагуудыг шинэ системд бүртгүүлж, бэлтгэл ажлыг хангуулах	2022 оны 12-р сард төсвийн 6 байгууллага шилэн дансны шинэ нэгдсэн цахим системд бүртгүүлж, бэлтгэл ажлыг хангуулж ажилласан. 2023 оны 1-р сараас эхлэн Шилэн дансны шинэ цахим системд тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
3	Хоршоо хөгжүүлэх сангаас шинээр олгож байгаа зээлүүдийг сумын хөгжлийн бодлого зорилтдоо нийцүүлэх оновчтойгоор шийдвэрлэж, өмнөх сум хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтрэлтийг бууруулж, хугацаа хэтрэлтийн түвшинг 15%-аас бага түвшинд хүргэх, гэрээний хугацаа дуусгавар болсон зээлүүдийг эргэн төлүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх ажлуудыг эрчимтэй зохион байгуулах	2022 онд Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох тэргүүлэх чиглэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 сарын 31-ны өдрийн дугаар 12/06 тогтооолоор 4 булэг бүхий 18 салбар чиглэлтэй баталсан. Үүний дагуу зээлийн төслийг хүлээн авч шийдвэрлэж байна. Хугацаа хэтрэлтийн түвшин 2023 оны 06 сарын байдлаар 22%-тай байна. Шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлсэн 6 иргэний 29,163.1 мян төгрөг байна.
4	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг явцын болон гүйцэтгэлийн хяналтыг эрс сайжруулж ажилласх	2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх нийт 14 хөрөнгө оруулалт, хетэлбөр, төсөл, арга хэмжээ тусгагдсан. 2023 оны хагас жилийн байдлаар 2-р багийн иргэний танхим барих ажлын тендерийг https://www.tender.gov.mn/ цахим хуудсанд зарлан шалгаруулж гүйцэтгэгчтэй 86,500.0 мян төгрөгийн гэрээ байгуулж 2 удаа явцын хяналт хийж 90% гүйцэтгэлтэй явж байна. Сумын төв доторх нийтийн эзэмшилийн гэрэлтүүлгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хог хаягдлыг цуглуулах зайлзуулах ажлын тендер шалгаруулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтийн шатандаа явж байна.

5	Хөрөнгө зарцуулах тухай шийдвэрийн төслийг боловсруулах, хянах, албажуулах тухай бүрд холбогдох хууль, журмын заалтуудыг зөв тусгах, хөрөнгө зарцуулалтын төсвийн тооцоог хавсаргаж, хувийн хэрэг бүрдүүлэлтийг иж бүрэн бүрдүүлж ажиллах	2023 оны хагас жилийн байдлаар сумын Засаг даргын хөрөнгө зарцуулах тухай 14 захирамжийн төслийг боловсруулж эрх зүйн үндэслэлийг ханггуулж ажиллаа. Захирамж бүрд тухайн арга хэмжээний төсвийн тооцоог хавсралтаар тусгаж, хувийн хэрэг нээн ажиллаж байна.
6	Малжуулах төслөөс зээл авч зээлийн гэрээний хугацаа бүрэн дууссан малчдын зээлийг 2023 оны эхний хагас жилд багтаан төлүүлж, аймгийн төрийн санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	2022.12.31-ны байдлаар 17 зээлдэгчийн 10,125.0 мян төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас хагас жилийн байдлаар 16 зээлдэгчийн 9,325,000 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээлдэгчид зээлээ бүрэн төлж барагдуулах талаар мэдэгдэл хариутай албан шаардлага хүргүүлж сар бүрийн 15-ны өдрөөр холбогдох ажиллаж байна.
7	Усны тоолуурын баталгаат хугацаа дууссан иргэн, аж ахуй нэгжийн тоолуурүүдэг баталгаажуулах, гүний ус ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгжийг тоолууржуулах ажлыг зохион байгуулах	Сумын хэмжээнд нийт 74 ширхэг гүний худаг бүртгэлтэйгээс гар худаг-17 ширхэг, мод услах зориулалттай-2 ширхэг, үндны усны-1 ширхэг, бэлчээрийн усан хангамж болон үндны зориулалттай-54 ширхэг худаг байна. Одоогоор сумын төвийн үндны усны худаг тоолуураар баталгаажсан. Бусад худгийг тоолууржуулахад төсөв санхүүжилтийн асуудал хүндрэлтэй байна.
8	Төрийн жинхэнэ албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүнд ороогүй, хууль тогтоомжид нийцээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн, хавсарсны нэмэгдэл, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байхад нь давхардуулан нэмэгдэл олгож байгааг таслан зогсоох	Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Г.Мөнхсаруулд байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцуулан ажиллуулж дээрх асуудлыг хариуцсаны нэмэгдлийг үндсэн цалиангийн 40 хувиар олгодог байсныг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны 6/21 дүгээр тушаалаар олгохыг хориглосон байна.

ТАЙЛАН ГАРГАСАН
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА

Г. АНХТӨР